



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: А.Нарандэлгэр Утас: 86001147 Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС А УДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МАНХАН СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ч.ЭНХТӨР ТАНАА

2024.02.23 № 1154
танай 2024.02.25 -ны № 07 -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 16 тоот тогтоолоор 14,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоож бүртгэлд тусган, 102,187.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Дэлхийн зөн олон улсын байгууллагын хандиваар дотуур байрын ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулсан, аймгийн хөрөнгө оруулалтаар 140.0 сая төгрөгийн хичээлийн 1-р байрны барилгын гадна засварын ажил хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Манхан сумын сургууль нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 53 арга хэмжээг төлөвлөж, 94.3 хувьтай дүгнүүлэн ажилласан байна.

Тайлант онд Дэлхийн зөн олон улсын байгууллагын хандиваар дотуур байрын ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулсан, аймгийн хөрөнгө оруулалтаар 140.0 сая төгрөгийн хичээлийн 1-р байрны барилгын гадна засварын ажил хийсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	150,030,443.71	246,715,183.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,190,056.64	83,028,319.73
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,190,056.64	83,028,319.73
3121	Төгрөг	2,190,056.64	83,028,319.73
31211	Төрийн сангийн харилцах	2,190,056.64	83,028,319.73
33	АВЛАГА	-	854,704.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	854,704.89
35	БАРАА МАТЕРИАЛ	147,840,387.07	162,832,158.71
351	Түүхий эд материал	30,633,386.83	33,699,686.83
35110	Тусгай зориулалттай материал	30,606,486.83	33,699,686.83
35130	Эм боох материал	26,900.00	-
354	Хангамжийн материал	116,967,000.24	128,892,471.88
35410	Бичиг хэргийн материал	190,500.00	222,500.00
35420	Аж ахуйн материал	2,952,000.00	1,766,952.72
35430	Сэлбэг хэрэгсэл	650,000.00	650,000.00
35440	Түлш, шатах тослох материал	434,000.00	200,000.00
35450	Барилгын засварын материал	258,000.00	278,000.00
35460	Хүнсний материал	19,806,174.00	27,986,470.00
35470	Бусад хангамжийн материал	92,676,326.24	97,788,549.16
35600	Мал амьтад	240,000.00	240,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,400,030,069.83	1,942,711,555.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,400,030,069.83	1,942,711,555.35
392	Биет хөрөнгө	1,333,262,569.83	1,875,971,555.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,442,836,697.00	1,999,297,357.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(339,737,556.76)	(435,768,143.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(866,666.58)	(1,266,666.54)

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	335,035,852.47	339,329,540.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(227,359,974.07)	(165,272,194.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	207,739,234.94	226,442,277.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(148,789,347.27)	(152,222,275.36)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	17,200,000.00	17,200,000.00
39217	Ном	45,204,330.10	46,231,661.10
393	Биет бус хөрөнгө	66,767,500.00	66,740,000.00
39301	Програм хангамж	330,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(302,500.00)	(330,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	66,740,000.00	66,740,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,550,060,513.54	2,189,426,738.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,447,992.13</u>	<u>2,419,181.49</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,447,992.13	2,419,181.49
413	Өглөг	3,447,992.13	2,419,181.49
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	38,380.87	166,312.19
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	867,710.96	-
4136	Бусад өглөг	2,541,900.30	2,252,869.30
41361	Байгууллагад төлөх өглөг	1,617,100.30	2,252,869.30
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	924,800.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,546,612,521.41</u>	<u>2,187,007,557.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,546,612,521.41	2,187,007,557.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,267,801,957.94	1,267,801,957.94
51101	Өмч: - төрийн	1,201,061,957.94	1,201,061,957.94
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	66,740,000.00	66,740,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(699,169,638.48)	(58,774,602.70)
51210	Өмнөх үеийн үр дүн	(699,169,638.48)	(699,169,638.48)
51220	Тайлант үеийн үр дүн	-	640,395,035.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	977,980,201.95	977,980,201.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,550,060,513.54</u>	<u>2,189,426,738.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,799,055,099.10	2,815,946,365.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,850,300.10	648,863,565.84
120	Нийтлэг татварын бус орлого	82,850,300.10	648,863,565.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,850,300.10	648,863,565.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,971,100.00	752,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,440,000.00	150,648.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,439,200.10	647,960,917.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,716,204,799.00	2,167,082,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,410,444,500.00	1,912,273,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,410,444,500.00	1,912,273,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,246,699.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,246,699.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	301,513,600.00	254,808,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	301,513,600.00	254,808,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,785,027,272.51	2,175,551,330.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,785,027,272.51	2,175,551,330.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,712,198,762.51	2,102,480,573.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,087,922,999.00	1,383,540,536.00
210101	Үндсэн цалин	1,087,922,999.00	1,331,247,622.00
210102	Нэмэгдэл	-	52,292,914.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,387,110.23	174,199,716.34
210201	Тэтгэврийн даатгал	93,539,359.30	119,495,525.84
210202	Тэтгэмжийн даатгал	10,927,917.54	13,892,305.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,715,454.03	11,083,844.28
210204	Ажилгүйдлийн даатгал	2,098,500.08	2,702,549.18

210205	Эрүүл мэндийн даатгал	21,105,879.28	27,025,491.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,773,710.96	249,760,056.78
210301	Гэрэл, цахилгаан	10,780,710.96	16,329,656.78
210302	Түлш, халаалт	232,393,000.00	232,630,400.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,788,790.00	6,556,948.00
210401	Бичиг хэрэг	2,256,000.00	273,998.00
210402	Тээвэр, шатахуун	6,532,790.00	6,282,950.00
2105	Нормативт зардал	63,065,511.30	86,326,332.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,086,050.00	469,900.00
210502	Хоол, хүнс	61,979,461.30	85,856,432.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,939,100.00
210604	Урсгал засвар	-	2,939,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,821,100.00	11,157,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,971,100.00	752,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,850,000.00	10,405,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,439,541.02	188,000,884.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,985,954.00	32,245,828.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,256,800.00	15,764,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,196,787.02	139,990,556.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,828,510.00	73,070,756.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,828,510.00	71,600,624.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72,828,510.00	71,600,624.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,470,132.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,470,132.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>14,027,826.59</u>	<u>640,395,035.78</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>14,027,826.59</u>	<u>640,395,035.78</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,267,801,957.94	977,980,201.95	(699,169,638.48)	1,546,612,521.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,267,801,957.94	977,980,201.95	(699,169,638.48)	1,546,612,521.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	640,395,035.78	640,395,035.78
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,267,801,957.94	977,980,201.95	(58,774,602.70)	2,187,007,557.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,721,615,899.00	2,167,985,448.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,411,100.00	902,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,411,100.00	902,648.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,411,100.00	902,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,971,100.00	752,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,440,000.00	150,648.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,716,204,799.00	2,167,082,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,410,444,500.00	1,912,273,900.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,410,444,500.00	1,912,273,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,246,699.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,246,699.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	301,513,600.00	254,808,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	301,513,600.00	254,808,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,719,425,842.36	2,087,147,184.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,719,425,842.36	2,087,147,184.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,643,310,342.36	2,003,072,808.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,087,914,849.76	1,381,076,874.66
210101	Үндсэн цалин	785,425,795.10	951,753,957.70
210102	Нэмэгдэл	261,279,696.17	362,510,768.36
210104	Урамшуулал	41,209,358.49	66,812,148.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,356,878.60	177,052,901.25
210201	Тэтгэврийн даатгал	92,573,600.00	120,406,412.05
210202	Тэтгэмжийн даатгал	10,793,500.00	14,165,507.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,801,163.78	11,316,985.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,178,200.00	2,833,181.46
210205	Эрүүл мэндийн даатгал	22,010,414.82	28,330,814.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,906,000.00	250,738,767.74
210301	Гэрэл, цахилгаан	9,009,600.00	17,197,367.74
210302	Түлш, халаалт	232,396,400.00	232,396,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,145,000.00
2105	Нормативт зардал	61,281,900.00	83,757,500.00
210502	Хоол, хүнс	61,281,900.00	83,757,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,815,700.00	2,600,000.00
210604	Урсгал засвар	3,815,700.00	2,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,821,100.00	11,229,667.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,971,100.00	752,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,850,000.00	10,477,667.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,213,914.00	96,617,098.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,372,339.00	80,795,598.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,841,575.00	15,821,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,115,500.00	84,074,376.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,115,500.00	82,604,244.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	76,115,500.00	82,604,244.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,470,132.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,470,132.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,190,056.64	80,838,263.09
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,190,056.64	80,838,263.09
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,190,056.64
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,190,056.64	83,028,319.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,175,175,600.00	2,085,677,052.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,175,175,600.00	2,085,677,052.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,088,490,300.00	2,003,072,808.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,454,104,500.00	1,381,076,874.66

210101	Үндсэн цалин	996,651,700.00	951,753,957.70
210102	Нэмэгдэл	397,614,700.00	362,510,768.36
210104	Урамшуулал	59,838,100.00	66,812,148.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,763,300.00	177,052,901.25
210201	Тэтгэврийн даатгал	123,599,100.00	120,406,412.05
210202	Тэтгэмжийн даатгал	14,541,000.00	14,165,507.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,632,900.00	11,316,985.84
210204	Ажилгүйдлийн даатгал	2,908,200.00	2,833,181.46
210205	Эрүүл мэндийн даатгал	29,082,100.00	28,330,814.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,208,900.00	250,738,767.74
210301	Гэрэл, цахилгаан	17,812,500.00	17,197,367.74
210302	Түлш, халаалт	232,396,400.00	232,396,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,145,000.00
2105	Нормативт зардал	83,757,500.00	83,757,500.00
210502	Хоол, хүнс	83,757,500.00	83,757,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,600,000.00	2,600,000.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	2,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,299,700.00	11,229,667.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	752,000.00	752,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,547,700.00	10,477,667.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,756,400.00	96,617,098.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,934,900.00	80,795,598.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,821,500.00	15,821,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,685,300.00	82,604,244.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,685,300.00	82,604,244.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,685,300.00	82,604,244.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,169,423,548.00	2,166,515,315.74

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,912,273,900.00	1,912,273,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,912,273,900.00	1,912,273,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	254,808,900.00	253,338,767.74
132001	Орон нутгийн төсвөөс	254,808,900.00	253,338,767.74
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,340,748.00	902,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	752,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,648.00	150,648.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,190,100.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,190,056.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		83,028,319.73

3 . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 16,930.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15,293.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 15,293.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Хичээл үйлдвэрлэлийн зардлаас бэлтгэсэн 14,955.9 мянган төгрөгийн багшийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг шууд зардлаар бүртгэсэн,
- Тооллогоор дутсан 134.9 кг цагаан будааны үнэ 337.3 мянган төгрөгийг ажиллагсдаас авах авлагад бүртгээгүй,
-

Залруулагдаагүй 1,637.5 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 4 зөрчил¹ илэрснээс, 470.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,167.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

3.1 ТӨЛБӨРИЙН АКТ

Шатахууны зардлаас 470.3 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайланд цалингийн зардлыг 4,576.4 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, шимтгэлийн авлага дутуу бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайланг засах хүсэлт гаргаж, залруулах арга хэмжээ авч, тооцоо нийлэн баталгаажуулах.

2. Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдэл ихтэй, 2.2 тн мах нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нөөцөлсөн махны чанарын алдагдуулахгүйгээр хадгалах арга хэмжээг авч, хүүхдийн хоолны чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах.

3. Биет бус хөрөнгө данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын эзэмшилд байгаа газрын мэдээллийг санхүүгийн тайланд тоо хэмжээг буруу тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшилд байгаа газрын хэмжээнд кадастрын зураг хийлгэж, санхүүгийн тайланд тоо хэмжээг зөв тусган тайлагнах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
1	2	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
	Манхан сумын сургууль	1	15,293.1			1	15,293.1	1	15,293.1				
Нийт дүн		1	15,293.1			1	15,293.1	1	15,293.1				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	3	4	5	6	7	8	9	10	11	12
	1	470.3	1	470.3						
Манхан сумын сургууль	3	1,167.30					3	1,167.30		

Нийт	4	1,637.50	1	470.3		3.0	1,167.3	
------	---	----------	---	-------	--	-----	---------	--

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-